



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09/06

Хөхбүрд

Жендэрийн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/618 дугаар тоот захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын урт дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Жендэрийн үндэсний хорооноос гаргасан шийдвэрийн дагуу ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Жендэрийн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга –	Засаг дарга
Гишүүдэд –	Сургуулийн захирал
	Цэцэрлэгийн эрхлэгч
	Соёлын төвийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга- Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр арга хэмжээг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарч, арга зүйгээр хангаж ажиллахыг Жендэрийн дэд хорооны дарга, нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгэм цахим бодлогын хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА  Б. ОТГОНБАЯР

648801046